

# Интернет

КтМС-ийн дотуур байранд нэгээс  $N$  хүртэл дугаарлагдсан  $N$  ширхэг чиглүүлэгч (router - роутэр) бие биенээсээ хангалттай хол байрлалд тархан байрласан байдаг. Оюутнууд бие биетэйгээ чатлах боломжтой байхын тулд тэдний чиглүүлэгчүүд нь шууд хоорондоо биш юм гэхэд өөр чиглүүлэгчээр дамжин холбогдсон байх ёстой. Зарим үед чиглүүлэгч байрласан зарим өрөөнд тог тасарснаас болж чиглүүлэгч унтарна. Оюутны байрны захиргаа нэг өдөр ийм тохиолдолд зөвхөн тухайн чиглүүлэгч унтрахаас гадна өөр бусад чиглүүлэгчид хоорондоо харьцах боломжгүй болж байгааг анзаарчээ. Энэ тохиолдолд унтарч байгаа чиглүүлэгчийг онцгой чиглүүлэгч гэж нэрлэе. Захиргаа нийт хэдэн онцгой чиглүүлэгч байгааг мэдэхийг хүсч байгаа тул түүнийг олох програм бич.

## Input

Оролт хэд хэдэн тестээс тогтоно. Тестийн нийт тоо 300-гаас хэтрэхгүй. Тест бүрт нэг сүлжээг тодорхойлно. Тестийн эхний мөрөнд чиглүүлэгчийн тоо  $0 < N < 100$  өгөгдөнө. Дараагийн мөрүүд тус бүрд чиглүүлэгчийн дугаар болон түүнтэй шууд холбогдсон байгаа чиглүүлэгчдийн дугаарууд зайгаар тусгаарлагдан байрлана. Ийм мөрүүд дээд тал нь  $N$  ширхэг байна. Ямар нэг хоёр чиглүүлэгчийн шууд холболт нь эдгээр мөрүүд дотор дор хаяж нэг удаа гарах тул энэ нь сүлжээг бүрэн тодорхойлно. Тест бүрийн сүүлийн мөр нь тэгийг агуулна. Сүүлийн тест нь  $N=0$  утгыг агуулна.

## Output

Оролтын сүүлчийнхээс бусад тест бүрд харгалзах тоог нэг нэг мөрөнд хэвлэнэ.

## Example

**Input:**

```
5
5 1 2 3 4
0
6
2 1 3
5 4 6 2
0
0
```

**Output:**

```
1
2
```